“ЖУУЛЧИН ГОВЬ”ХК-ийн

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг.

2015.04:15 Улаанбаатар хот

Жуулчин говь” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 04-р сарын 15-ны өдрийн 13.00 цагт “Монгол савхи” ХК-ийн хурлын танхимд болно.

1.Ирц гаргаж мэдээлэх

2.Хэлэлцэх асуудал танилцуулах /Хурлын дарга Д.Ганболд/

3.Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан /Гүйцэтгэх захирал П.Мөнгөнцэцэг/

4. Компанийн ТУЗ-ийн тайлан /ТУЗ-ийн дарга Д.Мөнхсайхан/

5: Компанийн аудитын хорооны тайлан /Аудитын хорооны дарга Ө.Будханд/

6. ТУЗ-ийн төсөв танилцуулах /ТУЗ-ийн дарга Д.Мөнхсайхан/

7. Тооллогын комиссыг сонгох

8. Зохион байгуулалтын асуудал /ТУЗ-ийн гишүүдийг сонгох/

9. Бусад

10. Санал шүүмжлэл

11. Тооллогын комиссын тогтоол танилцуулах /Тооллогын комиссын дарга/

12. Хурлаас гаргах шийдвэр тогтоолуудын төслийг танилцуулах, батлах /Хурлын дарга/

13. Хурлыг хаах

Хурлыг 2 цагт багтаан хуралдуулна.

Зохион байгуулах комисс

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо 59

2012 он 02 дугаар сарын 15-ны өдрийн

34 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр..."Жуулчин говь" ХК.......

Хаяг, утас...Хан-Уул дүүрэг Чингисийн өргөн чөлөө...

...Аянай нэгтгэсний байр Утас: 345959...

Хурал хуралдах огноо, цаг, газар

...2015. 04. 15. 13.00 цагт. "Монгол-савхи" ХК-ийн...

...байранд...

Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:

2015....оны.02....дугаар.сарын.23.....өдөр

Олон нийтэд зарлах огноо:

2015....оны....03..дугаар сарын..02..өдөр

Бүртгэх өдөр:

2015....оны..03..дугаар сарын..11..өдөр

Гэрээний дагуу хурлын баримт,бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо:

2015...оны..03..дугаар сарын..04...өдөр

Хүргүүлсэн огноо: ..........оны........дугаар сарын........өдөр

Хурлын баримт бичгийн хуудсын тоо....10....ширхэг....10....хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ

КОМИССЫН ДАРГА....С.Дархан..../С.ДАРХАНБААТАР/

...........оны.........дүгээр сарын..........өдөр

БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН......................./ /

..........оны.........дүгээр сарын........өдөр

# “ЖУУЛЧИН ГОВЬ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Жуулчин-Говь" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 13.00 цагт Улаанбаатар хотод "Монгол савхи" ХК-ийн хурлын танхимд болно.

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Ажнай корпорацийн байр

Бүртгэх өдөр: 2015.03.11

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан
2. Компанийн ТУЗ-ийн тайлан
3. Аудитын хорооны тайлан
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
5. ТУЗ-ийн 2014 оны зардлын төсөв

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбоотой бичиг баримтыг ажлын өдрүүдэд 900-1800 цагийн хооронд Ажнай корпорацийн байранд ирж танилцаж болно.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС:
ХАРИЛЦАХ УТАС: 345959, 99060160, 99250422

"Үндэсний мэдээ" сонин
2015.03.16

# “ЖУУЛЧИН ГОВЬ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Жуулчин-говь" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 13.00 цагт Улаанбаатар хотод "Монгол савхи" ХК-ийн хурлын танхимд болно.

**Хаяг: Улаанбаатар хот,
Хан-Уул дүүрэг, 2-р хороо,
Ажнай корпорацийн байр**

**Бүртгэх өдөр: 2015.03.11**

**Хурлаар хэлэлцэх асуудлууд:**

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан
2. Компанийн ТУЗ-ийн тайлан
3. Аудитын хорооны тайлан
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
5. ТУЗ-ийн 2014 оны зардлын төсөв

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбоотой бичиг баримтыг ажлын өдрүүдэд 9:00-18:00 цагийн хооронд Ажнай корпорацийн байранд ирж танилцаж болно.

**Хурал зохион байгуулах комисс:
Харилцах утас:
345959, 99060160, 99250422**

Өдрийн сонин
2015.03.16

# "ЖУУЛЧИН ГОВЬ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Жуулчин-Говь" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 13.00 цагт Улаанбаатар хотод "Монгол савхи" ХК-ийн хурлын танхимд болно.

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Ажнай корпорацийн байр

Бүртгэх өдөр: 2015.03.11

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан
2. Компанийн ТУЗ-ийн тайлан
3. Аудитын хорооны тайлан
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
5. ТУЗ-ийн 2014 оны зардлын төсөв

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбоотой бичиг баримтыг ажлын өдрүүдэд 900-1800 цагийн хооронд Ажнай корпорацийн байранд ирж танилцаж болно.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС
ХАРИЛЦАХ УТАС: 345959, 99060160, 99250422

"Үндэсний мэдээ" сонин
2015. 03. 02.

# "ЖУУЛЧИН ГОВЬ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Жуулчин-говь" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал **2015 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 13.00 цагт Улаанбаатар хотод "Монгол савхи" ХК-ийн хурлын танхимд** болно.

**Хаяг: Улаанбаатар хот,**
**Хан-Уул дүүрэг, 2-р хороо,**
**Ажнай корпорацийн байр**

**Бүртгэх өдөр: 2014.03.11**

**Хурлаар хэлэлцэх асуудлууд:**

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан
2. Компанийн ТУЗ-ийн тайлан
3. Аудитын хорооны тайлан
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
5. ТУЗ-ийн 2014 оны зардлын төсөв

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбоотой бичиг баримтыг ажлын өдрүүдэд 9:00-18:00 цагийн хооронд Ажнай корпорацийн байранд ирж танилцаж болно.

**Хурал зохион байгуулах комисс:**
**Харилцах утас:**
**345959, 99060160, 99250422**

"Өдрийн сонин"
2015. 03. 02

МОНСТА-АУДИТ MONSTA-AUDIT

Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн хараат бус аудитын [illegible]

## ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН

# " ЖУУЛЧИН ГОВЬ " ХК – ний захирал Ч.Мөнхтулга танаа

### Санхүүгийн тайлангуудын талаарх тайлан

Бид " Жуулчин Говь " ХК-ний 2014 оны 12 - р сарын 31 - ний өдрөөр байгуулсан санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд ба бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэсэн.

### Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн дагуу бэлтгэж, үнэн зөв танилцуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Энэхүү үүрэг хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгож авч хэрэглэх, байгууллагын үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх, санхүүгийн тайлангуудыг алдаа зөрчил ба залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүйгээр, үнэн зөвөөр толилуулахтай холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх зэрэг багтана.

### Аудитын хүлээх хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудад хараат бус дүгнэлт өгөх нь бидний үүрэг юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой итгэлтэй олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэх, шаардлагуудыг мөрдөж ажиллахыг шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудитын горимуудыг сонгох нь санхүүгийн тайлангууд нь алдаа зөрчил ба залилангаас материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээ багтах аудиторын шийдвэрээс хамаарна.

Тэдгээр эрсдэлүүдийг үнэлэх [illegible] санхүүгийн тайлангуудыг үнэн зөв бэлтгэж толилуулахтай холбоотой байгууллагын дотоод хяналтын системийг хэрэглэдэг [illegible] байгууллагын дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилготой бус, харин тухайн байдалд тохирсон аудитын горимуудыг тодорхойлохын тулд юм. Аудит нь байгууллагын удирдлагын сонгон хэрэглэж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой эсэх, нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудын бодитой эсэхийг үнэлэх ажлыг багтана.

Бидний гүйцэтгэсэн аудит нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болох чадвартай гэдэгт бид итгэлтэй байна.

### Дүгнэлт

Бидний дүгнэлтээр " ЖУУЛЧИН ГОВЬ " ХК-ний 2014 оны 12 - р сарын 31 - ний өдрөөр тайлагнасан санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээ нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Санхүүгийн тайлангийн хуулбарыг [illegible] хавсаргав.

ЗАХИРАЛ [illegible] Т.БАТБААТАР

Огноо: 2015 - 02 - 10

Улаанбаатар хот, [illegible] дүүрэг,
[illegible]
[illegible]
[illegible]
Утас: [illegible]
И-мэйл: [illegible]

Хавсралт 2

### " ЖУУЛЧИН ГОВЬ " ХК-ийн 2014 оны 12 сарын 31-ний өдрөөрх орлогын дэлгэрэнгүй тайлан

/ мян.төг /

| Үзүүлэлт | Аудитласан |
|---|---|
| Борлуулалтын орлого /цэвэр/ | 129 523,7 |
| Борлуулалтын өртөг | 34 128,3 |
| Нийт ашиг/алдагдал/ | 95 [illegible] |
| Түрээсийн орлого | |
| Хүүгийн орлого | |
| Ногдол ашгийн орлого | |
| Эрхийн шимтгэлийн орлого | |
| Бусад орлого | |
| Борлуулалт, маркетингийн зардал | |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 88 139,3 |
| Санхүүгийн зардал | |
| Бусад зардал | |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/ | |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/ | |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/ | |
| Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/ | |
| Бусад ашиг /алдагдал/ | |
| Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/ | 7 256,1 |
| Орлогын татварын зардал | 735,6 |
| Татварын дараах ашиг /алдагдал/ | 6 520,5 |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/ | |
| Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/ | 6 520,5 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | |
| * Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | |
| * Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | |
| * Бусад олз /гарз/ | |
| Орлогын нийт дүн | 6 520,5 |
| Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/ | |

Өдрийн сонин.
2015. 02. 11.

# "ЖУУЛЧИН ГОВЬ" ХК-ийн

## Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн бүртгэл

2015.04.15

Улаанбаатар хот

| № | Хувьцаа эзэмшигчдийн овог нэр | Регистерийн дугаар | Хувьцааны тоо | Харъяалагдах БДК | Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|
| 1 | А. Хуушаан | АЮ43052008 | 10501 | BDSEC | |
| 2 | Ч. Цэцэг-Өлзий | ЧХ62053013 | 14676 | ARGai Best. | - Хуушаан |
| 3 | Ч Тогтохбаяр | ХЙ76050506 | 1247 | BDSEC | |
| 4 | Г. Ганчимэг | ЧШ78091609 | 16829 | Life time | - Тогтохбаяр |
| 5 | Ажнай корпораци | 2064987 | 24288 | BDSEC | - Ганбаяр |
| 6 | П Нямдорж | ША80120714 | 1. | Гацуурт инвестмент | |
| 7 | Б. Эрдэнэжаргал | РА МП86102870 | 3 | Стандарт инвестмент | ✓ |
| 8 | Н Бирэнгэрэл | МВ88051308 | 1. | BDSEC | |
| 9 | С. Мягмарсүрэн | ХГ84091817 | 202 | ARD Capital | |
| 10 | | | | | |
| 11 | | | | | |
| 12 | | | | | |
| 13 | | | | | |
| 14 | | | | | |
| 15 | | | | | |
| 16 | | | | | |
| 17 | | | | | |
| 18 | | | | | |
| 19 | | | | | |
| 20 | | | | | |
| 21 | | | | | |
| 22 | | | 67748ш | 71.9% | |

94169ш 733

ЖУУЛЧИН ГОВЬ ХК

Ирц бүртгэсэн Н.Болормаа

69

# "ЖУУЛЧИН ГОВЬ" ХК

2015 оны 04-р сарын 15 өдөр № 01 Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН**
**ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

Тайланд өгсөн саналын
Тухай

2015 оны 4 дүгээр сар 15-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг үндэслэн ТОГТООХ НЬ:

"Жуулчин говь" ХК-ийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, Аудитийн хорооны тайлан, ТУЗ-ийн тайланг хувьцаа эзэмшигчид 100 хувийн саналаар зөвшөөрсөн тул хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан батлуулсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА Н.БОЛОРМАА

Хаяг: Ажнай корпорац, Чингисийн өргөн чөлөө-36, Хан-уул дүүрэг
Утас : 345959, Факс: 345959
E-майл: info@juulchingobi.com

70

# “ ЖУУЛЧИН ГОВЬ” ХК

2015 оны 04-р сарын 15 өдөр №02 Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

ТУЗ-ийн гишүүдийг сонгосон
саналын тухай

2015 оны 4 дүгээр сар 15-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Тус компаний хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бүгд ширхэг хувьцаа эзэмшигчид оролцож саналын хуудсаар өгсөн саналыг тоолоход:

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1.** | Д.Ганболд | 7523,7 | ширхэг саналаар | 99.9 | **хувь** |
| 2. | Д.Хуушаан | 7550.4 | ширхэг саналаар | 100 | хувь |
| 3. | Д.Мөнхсайхан | 7525.1 | ширхэг саналаар | 99.9 | хувь |
| 4. | Ч.Тогтохбаяр | 7523.7 | ширхэг саналаар | 99.9 | хувь |
| 5. | Ч.Мөнхтулга | 7523.7 | ширхэг саналаар | 99.9 | хувь |
| 6. | А.Цэцэгдэлгэр | 7523.7 | ширхэг саналаар | 99.9 | хувь |

ТУЗ-ийн хараат бус гишүүнд:

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7. | Н.Энхтуяа | 7530 | ширхэг саналаар | 100 | хувь |
| 8. | Ө. Будханд | 7524 | ширхэг саналаар | 99.9 | хувь |
| 9. | С.Дарханбаатар | 7523.7 | ширхэг саналаар | 99.9 | хувь |

тус тус сонгогдсон тул хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулан баталсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА Н.БОЛОРМАА

Хаяг: Ажнай корпорац, Чингисийн өргөн чөлөө-36, Хан-уул дүүрэг
Утас : 345959, Факс: 345959
E-майл: info@juulchingobi.com

71

# “ ЖУУЛЧИН ГОВЬ” ХК

2015 оны 04-р сарын 15 өдөр № 03 Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

ТУЗ-ийн төсвийн зардлын тухай

Компанийн тухай ауулийн 62 дугаар зүйлийн 1.13 дах заалт, хувьцаа эзэмшигчдийн санал хураалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

“Жуулчин говь” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 100 -ийн саналаар тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2015 оны урамшуулал , үйл ажиллагааны зардлын төсвийг 5,800.000 /Таван сая найман зуун мянга/ төгрөгөөр зөвшөөрсөн тул хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан батлуулсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА Н.БОЛОРМАА

Хаяг: Ажнай корпорац, Чингисийн өргөн чөлөө-36, Хан-уул дүүрэг
Утас : 345959, Факс: 345959
Е-майл: info@juulchingobi.com

“Жуулчин говь” ХК-ийн тооллогын комисс 2013 оны 04-р сарын 15-ны өдөр

## САНАЛ ХУРААЛТЫН ДҮН

| Хувьцаа эзэмшигчдийн нэрс | Хувьцааны тоо | Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайланг батлах | | Компанийн ТУЗ-ийн тайлангбатлах | | Компанийн аудитын тайланг батлах | | Компанийн ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчидэд өгсөн санал | | Компанийн 2015 оны ТУЗ-ийн төсөв 5,800000т | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Зөвшөөрсөн | Татгалзсан | Зөвшөөрсөн | Татгалзсан | Зөвшөөрсөн | Татгалзсан | Зөвшөөрсөн | Татгалзсан | Зөвшөөрсөн | Татгалз |
| Ажнай корпораци | 24288 | 24288 | | 24288 | | 24288 | | 24288 | | 24288 | |
| Н.Цэцэг-Өлгий | 14676 | 14676 | | 14676 | | 14676 | | 14676 | | 14676 | |
| Г.Ганчимэг | 16829 | 16829 | | 16829 | | 16829 | | 16829 | | 16829 | |
| Д. Хуушаан | 10501 | 10501 | | 10501 | | 10501 | | 10501 | | 10501 | |
| Н.Тогтохбаяр | 1247 | 1247 | | 1247 | | 1247 | | 1247 | | 1247 | |
| П.Нямдорж | 1 | 1 | | 1 | | 1 | | 1 | | 1 | |
| Б.Эрдэнэжаргал | 3 | 3 | | 3 | | 3 | | 3 | | 3 | |
| Н.Бүрэнгэрэл | 1 | 1 | | 1 | | 1 | | 1 | | 1 | |
| С.Мягмарсүрэн | 202 | 202 | | 202 | | 202 | | 202 | | 202 | |
| | | | | | | | | | | | |
| **Дүн** | 67748 | 67748 | | 67748 | | 67748 | | 67748 | | 67748 | |
| **Хувь** | 71,9% | 71,9% | | 71,9% | | 71,9% | | 71,9% | | 71,9% | |

ЖУУЛЧИН ГОВЬ ХК

**Тооллогын комиссын дарга** **Н.Болормаа**

73

# “ ЖУУЛЧИН ГОВЬ” ХК

2015 оны 04-р сарын 15 өдөр №01 Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ

Тайлан батлах
тухай

“Жуулчин говь” ХК-ийн 2015 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын /№01/ тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан, Аудитын хорооны тайлан, ТУЗ-ийн тайланг баталсугай.
2. “Жуулчин говь” ХК-ийн цаашдийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, үр ашигтай ажиллахыг Гүйцэтгэх захирал -/П.Мөнгөнцэцэг/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Д. ГАНБОЛД

Хаяг: Ажнай корпорац, Чингисийн өргөн чөлөө-36, Хан-уул дүүрэг
Утас : 345959, Факс: 345959
E-майл: info@juulchingobi.com

74

# “ ЖУУЛЧИН ГОВЬ” ХК

2015 оны 04-р сарын 15 өдөр №02 Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг батлах
тухай

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дахь заалт,тооллогын комиссын тогтоолыг (№ 2 ) үндэслэн ТОГТООХ НЬ:

Тус компаний хувьцаа эзэмшигчдийн саналыг үндэслэн ТУЗ-ийн гишүүнд :

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1. | Д.Ганболд | 7523,7 | ширхэг саналаар | 99,9 хувь |
| 2. | Д.Хуушаан | 7545,7 | ширхэг саналаар | 100 хувь |
| 3. | Ч.Мөнхтулга | 7523,7 | ширхэг саналаар | 99,9 хувь |
| 4. | Ч.Тогтохбаяр | 7523,7 | ширхэг саналаар | 99,9 хувь |
| 5. | А.Цэцэгдэлгэр | 7523,7 | ширхэг саналаар | 99,9 хувь |
| 6. | Д.Мөнхсайхан | 7524,3 | ширхэг саналаар | 99,9 хувь |

ТУЗ-ийн хараат бус гишүүнд:

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7. | Н.Энхтуяа | 7529,7 | ширхэг саналаар | 100 хувь |
| 8. | Ө. Будханд | 7536 | ширхэг саналаар | 100 хувь |
| 9. | С.Дарханбаатар | 7523,7 | ширхэг саналаар | 99,9 хувь |

тус тус сонгогдсон тул ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацааг хувь нийлүүлэгчдийн дараагийн хурал хүртэл баталсугай.

ЖУУЛЧИН ГОВЬ ХК

ХУРЛЫН ДАРГА Д.ГАНБОЛД

Хаяг: Ажнай корпорац, Чингисийн өргөн чөлөө-36, Хан-уул дүүрэг
Утас : 345959, Факс: 345959
E-майл: info@juulchingobi.com

# “ ЖУУЛЧИН ГОВЬ” ХК

2015 оны 04-р сарын 15 өдөр №03 Улаанбаатар хот

75

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ

ТУЗ-ийн зардлыг төсвийг
батлах тухай.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийг 62.1.13 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын /№03/ тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

“Жуулчин говь” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2015 оны урамшуулал , үйл ажиллагааны зардлын төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар 5,800.000 /Таван сая найман зуун мянга/ төгрөгөөр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА Д.ГАНБОЛД

Хаяг: Ажнай корпорац, Чингисийн өргөн чөлөө-36, Хан-уул дүүрэг
Утас : 345959, Факс: 345959
Е-майл: info@juulchingobi.com

“Жуулчин-говь” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн
ээлжит хурлын материал

2015-04-15 Улаанбаатар хот.

“Жуулчин-говь” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит 2015 оны 04-р сарын 15-ны өдрийн 13:00 цагт “Монгол савхи” ХК-ийн хурлын танхимд хуралдлаа.
Хурлын дарга Д.Ганболд: Хурлын дэгийг танилцуулаад саналаа өгнө үү? гэхэд
Хуралд оролцогчдын 100 хувийн саналаар хурлын дэгийг баталлаа. Нарийн бичиг С.Батбилэг хурлын ирцийг танилцуулав.
С.Батбилэг:”Жуулчин-говь” ХК-ийн хувьцааны 67748 ширхэг хувьцааг эзэмшигч 9 хувьцаа эзэмшигч хуралд хүрэлцэн ирсэн ба 71,9 хувийн ирцтэй байна. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дүгээр заалтыг үндэслэн ирц хангалттай гэж үзээд хурлыг эхлүүлж байна.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:
-Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан
-Компанийн ТУЗ-ийн 2014 оны тайлан
-Аудитын хорооны тайлан
-ТУЗ-ийн гишүүдийг сонгох
-Компанийн ТУЗ-ийн 2015 оны төсвийг батлах
Хурлын дарга Д.Ганболд: Хурлын дэгийн дагуу компанийн үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Мөнгөнцэцэг танилцуулав. /Хурлын материалд тайланг хавсаргав./
Хурлын дарга Д.Ганболд: Тайлангуудаа бүгдийг сонссоны дараа асуулт хариултаа явуулах дор дор нь сонсоод асуугаад явах уу? Гэхэд
Хуралд оролцогчдын 100 хувийн саналаар тайлангуудаа сонссоны дараа асуулт хариулт явуулахаар болов.
Хурлын дарга Д.Ганболд: ТУЗ-ийн 2014 оны тайланг танилцуулав. /Хурлын материалд тайланг хавсаргав./
Хурлын дарга Д.Ганболд: Аудитын хорооны тайланг танилцуул гэв.
Аудитын хорооны гишүүн Будханд тайланг танилцуулав. /Хурлын материалд тайланг хавсаргав./
А.Цэцэгдэлгэр: ТУЗ-ийн 2015оны зардлын төсвийг танилцуулав.
Хурлын дарга Д.Ганболд: Тайлангуудыг сонслоо та бүхэн асуух зүйл байвал асууя гэв.
П.Нямдорж: 2015 онд хэдэн төгрөгний ашигтай ажиллахаар төлөвлөсөн бэ?
Мөнгөнцэцэг: Яг тодорхой хэлэх тоо байхгүй байна. Одоогоор захиалга өгсөн 4 компани байна. Энэ жил жуулчдын тоо өсөх хандлагатай байгаа. Тийм болохоор одоохондоо яг нарийн тооцоо гараагүй байна.
С.Мягмарсүрэн: Хэдэн компанитай гэрээ хийгээд байна.
Мөнгөнцэцэг: хаврын аялал жуулчлалын үзэсгэлэнгээр 31 компанитай гэрээ хийгээд байгаа. Ноднин 21 компанитай гэрээ хийгээд 16 компани гэрээний дагуу жуулчид амраасан.
С.Мягмарсүрэн: Танайх бусад баазуудаас ялгарах онцлог юу байна.
Мөнгөнцэцэг: Анхны жуулчны бааз гэдгээрээ нэр хүндтэй.
П.Нямдорж: Одоо амрагч хүлээж авхаар гарах боллоо. Зээл авах уу?
Мөнгөнцэцэг: Энэ жилдээ зээл авахгүй гарах санаатай байна. Хонгорын бааз дээр Жуулчин говь-1 –ээс хэдэн гэр нэмж аваачиж барина. Энэ жил байгаа бололцоогоо ашиглаад гарна.Зээл авахгүй урьд оны зээлээ төлөх төлөвлөгөөтэй байна.
П.Нямдорж: 129 сая төгрөгийн ашиг гардаг юм байна. Үүний хэдийг нь Хонгорын баазаас олдог вэ?
Мөнгөнцэцэг: 60 орчим хувийг нь Хонгорын баазаас олдог. 24 гэр байдаг. Салхи шуурга ихтэй байдаг болохоор гэр их амархан мууддаг. Одоо байгаа гэрүүд их муудсан.

С.Мягмарсүрэн: Гэр нэмж барья гэхэд газар байгаа юу? Зам хэр байдаг юм бэ?
Мөнгөнцэцэг: Газар бол байгаа. Зам бол их муу. Ганц фургон машинтай, түүгээрээ л аж ахуйн ажлуудаа амжуулж байна даа.
С.Мягмарсүрэн: Зуны дөрвөн сар ажиллахад 6 сая төгрөгний ашигтай ажиллаж зүгээр нэг залуу хөтөч хийгээд явахад 3-4 доллар олоод байдаг.
Будханд: Зардал бол яалт ч үгүй өндөр гардаг. Цалинг нь голоод хүн ажилладаггүй.
П.Нямдорж: Борлуулалт цалингийн зардлыг бууруулах боломж бий юу?
Мөнгөнцэцэг: Борлуулалт цалинг бууруулах боломж байхгүй. Боловсон хүчний асуудал маш хүндрэлтэй байдаг. Бид боломжоороо орон нутгаас хүн авч ажиллуулдаг боломж цалин бага учраас яг тогтвортой ажиллах хүн олддоггүй 1 хүн 10-15, 20 хоног ажиллаад л буцдаг. Хотоос ажилчид авъя гэхээр хөдөө орон нутагт ажиллана гэдэг ойлголтоороо цалин доод тал нь 1 сая төгрөг нэхдэг. Ийм байдлаас болоод 1 хүн 1 хүний цалингаар 2-3 хүний ажил хийх тохиолдол байнга байдаг.
С.Мягмарсүрэн: Бусад амралт аялал жуулчлалын баазуудтай цаашид яаж өрсөлдөх вэ?
Мөнгөнцэцэг: Манай Хонгорын бааз тэмээн аялал, элсэн уул үзүүлэх, газрын байршил зэргээрээ харьцангуй давуу талтай. Мөн гүний худагтай. Ресторанд 40-50 хүн хүлээж авах хүчин чадалтай. Наад Жуулчинговь-1 бааз маань Шувуу ажиглах төв гэдгээрээ жуулчдын анхаарлыг татдаг. Жуулчин говь -1 бааз дээр нүүдлийн 120-иод төрлийн шувуу ажиглах давуу талтай байдаг. Мөн Монголын анхны аялал жуучлалын бааз гэдгээрээ нэр хүндтэй. Манай компани улсад ямар нэг өр төлбөр байхгүй. Татвар, шимтгэлийн асуудлыг цаг тухайд нь төлдөг.
С.Мягмарсүрэн: Аймагт очиж байгаа жуулчдын хэдэн хувийг хүлээн авч байна.
Мөнгөнцэцэг: 20-30 хувийг л авч байна. "Жуулчин-говь"-1 дээр гэхэд л эргэн тойрон шинэ баазууд нэмэгдсэн. Ер нь жилд 1-2 бааз нэмэгдэж байгаа нь манай баазын үйл ажиллагаанд маш их нөлөөлж байгаа.
Н.Бүрэнгэрэл: Дотоодын жуулчин яаж ирж очдог юм бэ?
Мөнгөнцэцэг: Ихэнх нь компаниар дамжиж ирдэг.
П.Нямдорж: Нэг хүний зардал хэдэн төгрөг байдаг юм бэ?
Мөнгөнцэцэг: Дотоодын жуулчинд 30,000-50000 төгрөг, гадаадын жуулчинд 60,000-70,000 төгрөг байгаа.
Б.Эрдэнэжаргал: Жуулчидаа яаж хүлээж авдаг вэ?
Мөнгөнцэцэг: Өөрсдөө голдуу унаагаараа ирдэг. Манайд захиалга өгвөл бид унааны асуудлыг тухайн үед нь ярьж зохицуулдаг. Энэ жил онгоцны асуудлаас болоод жуулчдын захиалга хойшлогдоод байна.
Хурлын дарга Мөнхсайхан: Хурлын дэгийн дагуу ТУЗ-ийн гишүүдийг сонгоно гээд гишүүдийн танилцуулгыг хийв.
Б.Эрдэнэжаргал: ТУЗ-ийн гишүүнд аялал жуулчлалын мэргэжлийн хүн байвал зүгээр байна.
Хурлын дарга Мөнхсайхан: Хоёр ч аялал жуулчлалын мэргэжилтэй хүн байгаа.
Н.Энхтуяа:Энэ жилээс эхлэн энэ компанийн хараат бус гишүүнээр орж ажиллах гэж байна. Тайланг сонслоо бүтэн жилийн тайлангаа тавьж байна. Ер нь бол ноднин ийм байлаа энэ жил ингэж ажиллахаар төлөвлөж байна гэж ярих ёстой. Үр ашгийн тооцоогоо хиймээр байна. 1000 гаруй жуулчин хүлээж авсан юм байна. Нэг жуулчнаас 10,000 төгрөгийн ашиг олж байвал 10 гаруй сая төгрөгийн ашигтай ажиллах боломж байна. Их тооцоотой ажилламаар байна. Ямар үйлчилгээ шинээр нэмж болох тал дээр анхаар бодох хэрэгтэй. Миний үүрэг гэдэг үүднээс энэ санаа оноог хэлж байна. Үйлчилгээний ажилтанг тогтвор суурьшилтай ажиллуулах тал дээр анхаарах хэрэгтэй. Үр ашгаа нэмэгдүүлэх, үргүй зардлыг багасгах тал дээр анхаар.
Н.Бүрэнжаргал: Очиж амрахад хувьцаа эзэмшигчдэд хөнгөлөлт үзүүлэх боломж байна уу?
Мөнгөнцэцэг: Тийм боломж бол бий.
Н.Энхтуяа: Шүүмжилдэг юм их дутмаг байна. Хувьцаа эзэмшигчид их ашигтай байгаасай, үргүй зардал бага гаргаасай гэдэг талаас нь ярьж хэлж байгаа. Тэгж байж энэ хүмүүс маань ногдол ашиг авна.

Хурлын дарга Д.Ганболд: Аймагт хэдэн компани нэмэгдсэн бэ?
Мөнгөнцэцэг: 10 хэдэн компани нэмэгдсэн байгаа.
Д.Хуушаан: Танайх өртэй байж яагаад ашигтай ажилласан гээд яриад байгаа юм бэ? Одоо хэдэн төгрөгний өр байна.
Мөнгөнцэцэг: 62 сая төгрөгний өртэй байгаа. 2011 онд авсан зээлээс 43 сая төгрөгийн өр хэвээр байна.
Д.Хуушаан: Тэгээд яагаад ашигтай ажилласан гээд байгаа юм бэ?
Мөнгөнцэцэг: Эргэлтийн хөрөнгө шүү дээ. Балансийн орлого зарлагаар ашигтай ажилласан гэж байгаа юм. Балансаар тэгж гараад байгаа юм. Тусламжийн 10 сая, зээл 24 сая бий.
Д.Хуушаан: Өрөө хүүгүй төлөөд явж байхад ийм байна шүү дээ. 24 саяас хэдийг нь төлсөн бэ?
Мөнгөнцэцэг: 5 саяыг нь төлсөн, 19 саяын өртэй байгаа.
Д.Хуушаан: Нэг УАЗ-469 машин байх ёстой тэр хаана байна.
Мөнгөнцэцэг: Тэр УАЗ-469 машин 2013 онд ажил хүлээж авахад элгээрээ бараг хэвтсэн, 2 дугуй байхгүй явдаггүй 2011 оноос хойш баазын хашаанд тавиатай ажил үүрэг гүйцэтгэх боломжгүй машин байсан. 2014 оны 8-р сард 1 сая төгрөгөөр Замын –Үүд рүү зарсан. Авсан хүмүүс ачаад явсан.
Н.Энхтуяа: 10 саяыг бид ийм юманд зарцуулаа гээд тайландаа тусгаад өгвөл их сайн байна. Авч ажиллуулдаг хүн дээ НДШимтгэл, ХАОАТатвар төлдөг үү?
Мөнгөнцэцэг: 8 хүнд л татварыг нь төлдөг, бусад хүмүүстэй гэрээт ажилчин гэдгээр явдаг.
Хурлын дарга Д.Ганболд: Хурлын дэгийн дагуу саналын хуудсаар санал авсан байгаа Н.Болормаа саналын дүнгээ танилцуул гэв.
Н.Болормаа: Санал хураалтын дүнг тооллогын комисс нэгтгэж, тогтоолын төслийг танилцуулав.
1. Саналын хуудсаар компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн тайлан, Аудитын хорооны тайланг хувьцаа эзэмшигчид 100 хувь зөвшөөрсөн байна.
2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Д.Хуушаанд 7550,4 ширхэг саналаар буюу 100 хувь, нэр дэвшигч Д.Ганболд, Д.Мөнхсайхан, Ч.Тогтохбаяр, Ч.Мөнхтулга, А.Цэцэгдэлгэр нарт 7523,7 ширхэг санал буюу 99,9 хувь, хараат бус гишүүнд нэр дэвшигч Н.Энхтуяад 7530 ширхэг саналаар буюу 100 хувь, Ө.Будханд, С.Дарханбаатар нарт 7524, 7523,7 ширхэг саналаар буюу 99,9 хувийн саналаар тус тус санал авсан байна.
3. Саналын хуудсаар хувьцаа эзэмшигчдийн 71,9%-ийн саналаар ТУЗ-ийн 2015 оны зардлын төсвийг 5,800.000 төгрөгөөр зөвшөөрсөн байна.

Хурлын дарга Д.Ганболд: "Жуулчин-говь" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төслүүдийг танилцуулж баталлаа.

1. Тогтоол №1 Тайлан батлах /2014 оны үйл ажиллагааны тайлан,Аудитын хорооны тайлан,ТУЗ-ийн тайлан/
2. Тогтоол №2 ТУЗ-ийн гишүүдийг батлах
3. Тогтоол №3 ТУЗ-ийн 2015 оны зардлын төсвийг батлах

Хуралд хүрэлцэн ирж оролцсон хувьцаа эзэмшигч та бүхэнд баярлалаа, та бүхний ажил амьдралд хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе гэв.

Хурлыг 14:50 минутанд хаав.

Хянасан: Хурлын дарга [signature] Д.Ганболд

Тэмдэглэл хөтөлсөн: [signature] С.Батбилэг